

“ДАРХАН ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ГАЗАР”
ОНӨААТҮГ-ЫН 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төсвийн Ерөнхийлөн захирагч

Төлөвлөгөөг хянасан:
Дархан-уул аймгийн
Засаг дарга
(албан тушаал)

Тэмдэг



(Б.АЗЖАРГАЛ)

(огноо)

Төсвийн Шууд захирагч

Төлөвлөгөө баталсан:
“Дархан-Хот байгуулалт
барилга захиалагчийн газар”
ОНӨААТҮГ-ын Дарга
(албан тушаал)

Тэмдэг



(Д.БАТБАЯР)

2024.01.02
(огноо)

“Дархан-Хот байгуулалт, барилга захиалагчийн газар” ОНӨААТҮГ-ын
2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө

Байгууллагын үйл ажиллагааны ЭРХЭМ ЗОРИЛГО нь: Төсөл хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг ханган, хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх.

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэл байгаа бодлогын баримт бичиг	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хугацаа I-IV улирал/	Хариуцах нэгж
Стратеги төлөвлөгөөний зорилго-1. Барилга байгууламжийг шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах ажлыг гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлж эхлүүлэх, батлагдсан зураг төсөл, стандарт, техникийн нөхцөл болон технологийн хяналт тавьж гүйцэтгэлийг баталгаажуулах, хөрөнгө оруулалт, санхүүгийн эх үүсвэрийг үр ашигтай зарцуулж төлөвлөсөн хугацаанд ашиглалтад оруулах.							
1	Зорилт 1- Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2024 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Дархан-Уул аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний төсөв /Дархан-Уул аймаг/, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн 2023 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр батлагдсан “Аймгийн 2022 оны төсвийн гүйцэтгэл, 2024 оны төсөв батлах тухай” 54 дүгээр тогтоол, сумдын ИТХ-ын төлөөлөгчдийн тогтоолоор батлагдсан төсөвт тусгагдсан төсөлд захиалагчийн техникийн шаталсан хяналтыг хэрэгжүүлж гүйцэтгэлийг үе шатны хуваарийн дагуу хянан баталгаажуулах.						
1.1	Барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний 151 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналт хэрэгжүүлэх.	233.0 тэрбум төгрөгийн өртөг бүхий 151 төсөл хөтөлбөрт захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлнэ. /2024 онд санхүүжих дүн 96.2 тэрбум төг/	-2023-2024 онд үргэлжлэн хэрэгжих 48 төсөл арга хэмжээ -2024 онд шинээр хэрэгжих 103 төсөл, арга хэмжээнд буюу нийт 151 төсөл хөтөлбөрт захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлнэ.	2023 оны жилийн эцсийн байдлаар Монгол улсын засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, аймгийн эдийн засаг нийгмийг 2023 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Дархан-уул аймгийн Засаг даргын 2021-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 2022-2023 онд шилжин хэрэгжиж буй 50 төсөл арга хэмжээ, 2023 онд шинээр гэрээ байгуулан хэрэгжиж байгаа 26.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 160 төсөл, арга хэмжээ буюу нийт 147,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 210 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг	2024 онд Дархан-уул аймагт баригдах барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилт, авто зам, инженерийн шугам сүлжээ, гэрэлтүүлэгийн 233.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 151 төсөл, арга хэмжээнд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлнэ. 2023-2024 онд шилжин хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнээс 2023 онд 63,4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл хийгдсэн. 2024 онд 96.2 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэлийг	1-4 улирал	ИТА

20

			хэрэгжүүлж ажиллалаа. Техникийн хяналтаар: - Төсөл, арга хэмжээний тоо: 210 - Төсөвт өртөг: 147,6 тэрбум төг - Өгсөн зөвлөмжийн тоо, үүрэг даалгаврын биелэлт: 761 (96,3%) - Баталгаажуулсан ил, далд ажлын актууд, рекуст: 2739 - Фото зургаар баримтжуулсан байдал: 6193 - Лабораторийн сорил шинжилгээ: 417 - Авто замын нягтын хэмжилт хэмжилт: 598 цэг - Геодезийн хэмжилт шалгалт: 7333 цэг - Гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт: 295 - Санхүүжилт баталгаажуулсан дүн- 80,0 тэрбум төг Төсвийн хэмнэлт: - Магадлашгүй ажлын зардлаас 186,9 сая төгрөг - Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангаж хийгдээгүй ажлын зардлаас -139,2 сая төгрөг - Нийт 326,1 сая төгрөг Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн: 162 төсөл, арга хэмжээ 2024 онд шилжин хэрэгжих 48 төсөл, арга хэмжээ	баталгаажуулна. Дээрх 151 төсөл хөтөлбөрт захиалагчийн шаталсан техник хяналтыг хэрэгжүүлж барилга байгууламжийн норм нормативын баримт бичиг, тухайн барилгын ажлын батлагдсан зураг төсөл болон төсөв, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээнд тусгасан барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан баталгаажуулж барилга байгууламжийг байнгын ашиглалтад хүлээлгэн өгөх. 2024 онд шилжин хэрэгжих төсөл - УТХО-83,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 18 төсөл - ОНТХО-4,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл - ОНХС-4,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл - Азийн хөгжлийн банкны 10,3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр хийгдэж буй 1 төсөл, арга хэмжээ - Бусад эх үүсвэрээр санхүүжигдэх 1 төсөл, арга хэмжээ		
--	--	--	--	---	--	--

1.2 БАРИЛГА УГСРАЛТ-Зорилго 1.2 Барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянаж баталгаажуулах

1.2.1	Нийт 64 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын үе шатны хуваарийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянаж баталгаажуулах.	Нийт 86.6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 64 төсөл арга хэмжээнд (2024 онд санхүүжих дүн 37.1 тэрбум төгрөг)	-2023-2024 онд үргэлжлэн хэрэгжих 21 төсөл арга хэмжээ -2024 онд шинээр хэрэгжих 43 төсөл арга хэмжээ	2023 оны жилийн эцсийн байдлаар барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 2022-2023 онд шилжсэн 41,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 20 төсөл, арга хэмжээ, 2023 онд шинээр хэрэгжиж буй 6.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 84 төсөл нийт 47.9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 104 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж ажиллалаа Техникийн хяналтаар: • Төсөл, арга хэмжээний тоо: 104 • Төсөвт өртөг: 47.9 тэрбум төг • Өгсөн зөвлөмжийн тоо, үүрэг даалгаврын биелэлт: 399 зөвлөмж, биелэлтийн хувь-96% • Баталгаажуулсан ил, далд ажлын актууд: 507 • Фото зургаар баримтжуулсан: 1631 • Лабораторийн сорил шинжилгээ: 226 • Гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт: 135 удаа • Санхүүжилт баталгаажуулсан дүн-25,3 тэрбум төгрөг Төсвийн хэмнэлт: • Хийгдээгүй ажлын зардлаас 32,5 сая төгрөг • Магадлашгүй ажлын зардлаас 9,7 сая төгрөг • Нийт 42,2 сая төгрөг Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн: • 83 төсөл, арга хэмжээ Үргэлжилж хэрэгжиж байгаа: • 21 төсөл арга хэмжээ	Барилга угсралт, засвар шинэчлэлт, тохижилтын 64 төсөл/ -Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх. -Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. - Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	2-4 улирал	Барилгын инженер
-------	--	---	--	--	---	------------	------------------

1.3 ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭ								
1.3.1 ЦЭВЭР УС, ДУЛААН ХАНГАМЖ, БОХИР УС ТАТАН ЗАЙЛУУЛАХ								
Зорилго 1.3.1 Инженерийн шугам сүлжээ шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.								
1.3.1	Нийт 13 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.	26,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл, арга хэмжээ /2024 онд санхүүжих дүн 10,3 тэрбум төгрөг/	-2023-2024 онд үргэлжлэн хэрэгжих 10 төсөл арга хэмжээ -2024 онд шинээр хэрэгжих 3 төсөл арга хэмжээ	2022-2023 онд шилжсэн 29 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл арга хэмжээ, 2023 онд шинээр хэрэгжиж буй 3,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 38 төсөл буюу нийт 32,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 48 төсөл хөтөлбөрт захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналтыг хэрэгжүүлэн ажиллалаа.	Техникийн хяналтаар: ➢ Төсөл, арга хэмжээний тоо: 48 ➢ Төсөвт өртөг: 32.6 тэрбум төг ➢ Өгсөн зөвлөмжийн тоо, үүрэг даалгаврын биелэлт: 68 ➢ Баталгаажуулсан ил, далд ажлын актууд: 213 ➢ Фото зургаар баримтжуулсан: 765 ➢ Лабораторийн сорил шинжилгээ: 4 ➢ Гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт: 73 удаа ➢ Санхүүжилт баталгаажуулсан дүн-18.9 тэрбум төгрөг Төсвийн хэмнэлт: • Хийгдээгүй ажлын зардлаас 79,0 сая төгрөг • Магадлашгүй ажлын зардлаас 51,1 сая төгрөг • Нийт 130,0 сая төгрөг Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн: • 38 төсөл, арга хэмжээ Үргэлжилж хэрэгжиж байгаа: • 10 төсөл арга хэмжээ	Инженерийн шугам сүлжээний 13 төсөл -Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх. -Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. -Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	2-4 улирал	Сантехникийн инженер

1.3.2 ЦАХИЛГААН ХАНГАМЖ, ГЭРЭЛТҮҮЛЭГ -Зорилго 1.3.2 Цахилгаан хангамж, гэрэлтүүлэгийн ажлыг шинээр угсрах, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах							
1.3.2	Нийт 13 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах	2.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 13 төсөл /2023 онд санхүүжих дүн 2,2 тэрбум төгрөг/	-2023-2024 онд үргэлжлэн хэрэгжих 1 төсөл 2024 онд шинээр хэрэгжүүлэх 12 төсөл	2022-2023 онд шилжин хэрэгжиж буй 13,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, 2023 онд шинээр гэрээ байгуулан хэрэгжиж байгаа 2,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл буюу нийт 15,9 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөлд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техник хяналт хэрэгжүүлэн ажиллалаа. Техникийн хяналтаар: • Төсөл, арга хэмжээний тоо: 15 • Төсөвт өртөг: 15,9 тэрбум төг • Өгсөн зөвлөмжийн тоо, үүрэг даалгаврын биелэлт: 148 зөвлөмж, биелэлтийн хувь-96% • Баталгаажуулсан ил, далд ажлын актууд: 340 • Фото зургаар баримтжуулсан: 680 • Лабораторийн сорил шинжилгээ: 32 • Гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт: 23 удаа • Санхүүжилт баталгаажуулсан дүн- 9,8 сая төгрөг Төсвийн хэмнэлт: • Хийгдээгүй ажлын зардлаас 15.0 сая төгрөг • Магадлашгүй ажлын зардлаас 78.2 сая төгрөг • Нийт 93,2 сая төгрөг Байнгын ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээ: -14 төсөл, арга хэмжээ 2024 онд шилжин хэрэгжих: -1 төсөл, арга хэмжээ	Цахилгаан хангамж, гэрэлтүүлгийн 13 төсөл -Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх. -Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. - Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	2-4 улирал	Цахилгааны инженер

1.4 АВТО ЗАМ, ГАРЦ ЗОГСООЛ-Зорилго 1.4 Авто зам, зогсоол шинээр барих, өргөтгөх, шинэчлэн засварлах үйл ажиллагаанд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.							
1.4.1	Нийт 60 төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж барилга угсралтын ажлын гүйцэтгэлийг баталгаажуулж хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэн байнгын ашиглалтад оруулах.	116,3 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 60 төсөл арга хэмжээ /2024 онд санхүүжих дүн 46,5 тэрбум төгрөг/	-2023-2024 онд үргэлжлэн хэрэгжих 16 төсөл арга хэмжээ 2024 онд шинээр хэрэгжих 44 төсөл арга хэмжээ	2023 оны жилийн эцсийн байдлаар зам, замын байгууламжийн 2022-2023 онд шилжин хэрэгжиж байгаа 36,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 11 төсөл, арга хэмжээ, 14,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 31 төсөл, арга хэмжээ буюу нийт 50,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл арга хэмжээнд захиалагчийн техникийн өдөр тутмын болон үе шатны хяналтыг хэрэгжүүлж ажиллалаа. Техникийн хяналтаар: • Төсөл, арга хэмжээний тоо: 42 • Төсөвт өртөг: 50,6 тэрбум төг • Өгсөн зөвлөмжийн тоо, үүрэг даалгаврын биелэлт: 146 зөвлөмж, биелэлтийн хувь-95,5% • Баталгаажуулсан далд ажлын актууд: 487 • Фото зургаар баримтжуулсан: 3117 • Лабораторийн сорил шинжилгээ: 155 • Нягт шалгалт: 598 цэг • Геодезийн хэмжилт-7333 цэг • Рекуст /Үе шатны ажил эхлүүлэх/: 1192 удаа • Гүйцэтгэлийн хянан баталгаажуулалт: 70 удаа • Санхүүжилт баталгаажуулсан дүн- 25,7 тэрбум төгрөг Байнгын ашиглалтад хүлээлгэн өгсөн төсөл, арга хэмжээ: • 26 төсөл, арга хэмжээ 2024 онд шилжин хэрэгжих: • 16 төсөл, арга хэмжээ	Авто зам, замын байгууламжийн 60 төсөл -Зураг төслийг судалж дүн шинжилгээ хийх. -Ажил эхлэх объект тус бүр дээр хувийн хэрэг нээж өдөр тутмын мэдээллээр баяжуулан хөтлөх. -Үе шатны ажил бүрийг хэмжин шалгаж хүлээж авах, хэрэглэгдсэн материал, хийц бүтээцийн лабораторийн шинжилгээний сорил авч актаар баталгаажуулах. - Дараагийн үе шатны ажлын зөвшөөрлийг олгох. -Гүйцэтгэлийг батлагдсан төсвийн дагуу хянаж санхүүжүүлэх.	2-4 улирал	Авто замын инженер

А

1.5 Гүйцэтгэлийг төсөв хянан баталгаажуулах							
"Барилга байгууламж шинээр барих, өргөтгөх шинэчлэн засварлах төсөл арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны хяналт хэрэгжүүлж барилгын ажлын тоо хэмжээ, төсөв гүйцэтгэлийг төсөл, арга хэмжээ нэг бүрээр нь тулган шалгаж хянан баталгаажуулах"							
1.5.1	Барилга угсралт, авто зам, замын байгууламж, инженерийн шугам сүлжээний 151 төсөл, арга хэмжээнд төсвийн хяналт хийж баталгаажуулах.	233,0 тэрбум төгрөгийн өртөг бүхий 151 төсөл хөтөлбөрт захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлнэ. /2024 онд санхүүжих дүн 96,2 тэрбум төг/	233,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 101 төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн төсөвт хяналт хийж, ажлын тоо хэмжээг баталгаажуулах	2023 оны жилийн эцсийн байдлаар нийт 147,6 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 210 төсөл, арга хэмжээнд захиалагчийн өдөр тутмын болон үе шатны техникийн хяналтыг хэрэгжүүлж ажилласан ба 80,0 тэрбум төгрөгийн 295 удаагийн гүйцэтгэлийг хянан баталгаажуулсан байна. Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангаснаар магадлашгүй ажлын зардлаас 186,9 сая төгрөг, хийгдээгүй ажлын зардлаас 139,2 сая төгрөг буюу нийт 326,1 сая төгрөгийн хэмнэлт үүсгэн ажиллалаа. Төсвийн хэмнэлт: -Инженерийн оновчтой шийдэл гаргаснаар: 139,2 сая төгрөг -Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангаснаар магадлашгүй ажлын зардлаас 186,9 сая төгрөг Нийт 326,1 сая төгрөг	Төсвийн зарцуулалтын үр ашигтай байдлыг хангана.	2-4 улирал	ИТА, Төсөвчин
СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО 2- Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх.							
2.1 Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах, сургалтын төлөвлөгөөний дагуу сургалт зохион байгуулж ажилчдын мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх.							
2.1.1	Хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангах.		Хамт олны багаар ажиллах болон мэргэжлийн үр чадварыг дээшлүүлэх.	-Байгууллагын ИТА албан хаагчдыг ажил үүргээ гүйцэтгэхэд шаардлагатай ажлын байр, тоног төхөөрөмж, бичиг хэрэг, автомашин, багаж хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцас, үндсэн цалин, хоол унааны мөнгө, сар бүр үр чадварын нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал зэргийг олгож ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж ажиллалаа. Үндсэн 8 ажилтан, гэрээт 3 ажилтан ажиллуулан нийт 11 хүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явууллаа. 2023 онд ажилчдын цалин хөлсийг газрыг даргын тушаалаар нэмэгдүүлсэн ба хоолны зардлыг өдрийн 8000 төгрөг, унааны зардлыг 2000 төгрөг болгож нэмэгдүүлсэн. Ажлын үр дүн, гүйцэтгэлийг харгалзан үзэж үр чадварын нэмэгдэлд 166,6 сая төгрөг, үр дүнгийн урамшуулалд 12,3 сая төгрөг, хоол унааны хөнгөлөлтөд 13,6 сая төгрөгийн нэмэгдлийг тус тус олгосон.	Хамт олныг удирдан зохион байгуулах, багаар ажиллах, өөрчлөлтийг хүлээж авах, оновчтой шийдвэр гаргах, мэргэжлийн үр чадвартай инженер техникийн ажилтан, албан хаагчид бүхий хамт олныг бүрдүүлсэн байна.	1-4 улирал	Байгууллагын удирдлага

2.1.2	Сургалтын хэрэгцээг тодорхойлж төлөвлөгөө боловсруулан, төлөвлөгөөний дагуу сургалтанд хамрагдах, гүйцэтгэгч байгууллагын ИТА, албан хаагчдад сургалт зохион байгуулах.	10,0 сая төгрөг	Газрын сургалтын төлөвлөгөөний дагуу инженер техникийн ажилтан, албан хаагчдыг сургалтанд хамруулж мэдлэг мэргэшлийг дээшлүүлэх. Гүйцэтгэгч байгууллагын ИТА, албан хаагчдад гүйцэтгэлийн талаар сургалт зохион байгуулах.	2023 оны байгууллагын батлагдсан сургалтын төлөвлөгөөний дагуу ИТА, албан хаагчид нь мэдлэг мэргэшлээ дээшлүүлэн суралцсан байна. -ИШС хариуцсан инженер Т.Сүх-Очир "Мэргэшсэн инженерийн зэрэг горилох сургалт"-д хамрагдсан. -Нягтлан бодогч С.Нарангарав нь "Авто замын төсөвчин"-ний сургалтад хамрагдсан. -Архив бичиг хэрэг нярав А.Нарангарав нь Архивын ерөнхий газраас зохион байгуулсан Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам, хөтлөх хэргийн нэрийн жагсаалт боловсруулах, хэрэг бүрдүүлэх, байгууллагын архивт баримт шилжүүлэх ажлын зохион байгуулалт, баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй, байгууллагын архивын баримтад нягтлан шалгалт хийх, хадгаламжийн нэгж бүрдүүлэх, данс бүртгэл үйлдэх арга зүй сэдэвт сургалтуудад онлайнаар хамрагдсан. -Авто замын инженер Б.Мөнх-Амар нь "Авто замчдын холбоо"-ноос зохион байгуулж буй "Хяналтын инженер"-ийн зэрэг сунгуулах сургалтад 12 дугаар сард хамрагдсан. -Сургалтын зардалд нийт 2,431,000 төгрөгийг зарцуулсан. Байгууллагын дотоод болон бусад байгууллагаас зохион байгуулсан сургалтуудад ИТА, албан хаагчид нь тухай бүр хамрагдсан. Жишээлбэл: -Сангийн яамны төсвийн хөрөнгө оруулалтын программын тухай сургалт -Албан хэрэг хөтлөлт, архивын хадгаламжийн нэгж үдэж хавтаслах тухай сургалт -“Ашиг сонирхлын зөрчил ба авилга” сэдэвт сургалт -Барилгын норм дүрэм, шинэ техник технологийн тухай ИТА хоорондоо туршлага, мэдлэг солилцох гэх мэт. -“Сэтгэл зүйн эрүүл мэнд ба ажил амьдралын тэнцвэр” сургалт -Ил тод байдлыг нэмэгдүүлэх, авлига ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, төрийн албан хаагчийн ёс зүй сэдэвт сургалт гэх мэт.	Байгууллагын сургалтын төлөвлөгөөний дагуу инженер техникийн ажилтан, албан хаагчдыг мэргэжлийн сургалтад хамруулж мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх, Гүйцэтгэгч байгууллагуудын ИТА, албан хаагчдад гүйцэтгэл хэрхэн гаргах, тайлагнах талаар сургалт зохион байгуулах.	1-4 улирал	Байгууллагын удирдлага, ерөнхий инженер
-------	---	-----------------	--	--	--	------------	---

2.2 Мэдээ тайлан гаргах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах							
2.2.1	Мэдээ тайлан гаргаж, мэдээллийн сан бүрдүүлэх	Төсөв шаардагд ахгүй.	Барилга угсралтын явцын мэдээ тайланг тогтмол гаргаж газрын удирдлага болон холбогдох байгууллагуудад хүргүүлэх. Мөн төсөл арга хэмжээ бүрээр мэдээллийн сан бүрдүүлэх.	-Барилга угсралтын ажлын явцын мэдээ, тайланг долоо хоног бүр аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, Барилгын хөгжлийн төвд хүргүүлэн ажилласан. -2023 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээ бүрээр объектын хагас болон бүтэн жилийн тайланг гарган газрын мэдээллийн сан бүрдүүлсэн ба тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т хүргүүлэн ажилласан. -Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах Мон-3244/3245 төсөл"-ийн ажилд захиалагчийн техникийн хяналт хэрэгжүүлж сар бүр төлөвлөгөө, тайланг Дархан төслийн удирдах нэгжид хугацаанд нь хүргүүлэн ажиллаа. -Байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулсан ба худалдан авах ажлын төлөвлөгөө, тайланг аймгийн ОНӨГ-т хугацаанд нь хүргүүлсэн. -Мөн 2022 оны жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан, 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, 2023 оны эхний хагас жил, бүтэн жилийн гүйцэтгэлийн тайланг батлуулан аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлсэн. -2023 оны байгууллагын жилийн эцсийн үйл ажиллагааны тайланг аймгийн ИТХ-ын тэргүүлэгчид танилцуулла. -Санхүүгийн ил тод байдлын мэдээг shilendans.gov.mn сайтад сар бүр хугацаанд нь гаргаж олон нийтэд мэдээлсэн. -Мөн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гарган Пийк ом аудит ХХК-иар баталгаажуулан холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. -Сар бүр НӨАТ тайлан, НДШ тайлан, улирал бүр ХХОАТ тайлан, ААНОАТтайланг гарган холбогдох байгууллагуудад хүргүүлэн ажилласан. -Байгууллагын ХШҮ-ний тайланг хугацаанд нь гарган аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэст хүргүүлж 97.6% ийн үнэлгээ авсан. -Байгууллагын дотоод орчинд Able цахим программыг ашиглан тус газарт хаяглан ирүүлсэн 687 ирсэн бичиг, 840 явуулсан бичиг, А тушаал 119ш, Б тушаал 68ш тушаал, шийдвэрийг сканердан оруулж цахим архивын мэдээллийн сан үүсгэн ажилласан ба ИТА, албан хаагчид ирсэн бичгүүдийг хугацаанд нь шийдвэрлэн хаасан. -Газрын архивт 2023 оны жилийн эцсийн байдлаар 751ХН хадгалагдаж байгаа ба мэдээг аймгийн Архивын тасагт хүргүүлсэн.	Төсөл бүрээр мэдээллийн санг бүрдүүлж, өдөр тутмын мэдээллээр баяжуулж хувийн хэрэг үүсгэнэ. Мэдээ тайланг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлнэ.	1-4 р улирал	ИТА, ажигчид

2.2.2	Холбогдох байгууллагуудыг мэдээллээр хангах.	Төсөв шаардагд ахгүй.	Аймаг орон нутгийн удирдлага болон холбогдох байгууллагуудыг барилга угсралтын төсөл хөтөлбөр, арга хэмжээний явцын тухай мэдээллээр хангаж ажиллах.	Дархан-Уул аймагт улсын болон орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаадын зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа барилга угсралт, авто зам, замын байгууламж, ИШС-ний 210 төсөл арга хэмжээний ажлын явцын мэдээ, мэдээлэл, шийдвэрлэх асуудлуудыг аймгийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын хурлаар буюу аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т долоо хоног бүрийн мягмар гаригт буюу нийт 48 удаа мэдээ тайланг хэлэлцэж хурлын тэмдэглэлээр баталгаажуулан зохих шийдвэрүүдийг гаргуулж ажилласан. УИХ-ын гишүүн Г.Дамдинням, УИХ-ын гишүүн Б.Баттөмөр, УИХ-ын гишүүн Б.Жавхлан, Соёлын яамны сайд Ч.Номин, Барилгын хөгжлийн төвийн удирдлагууд, аймаг сумдын Дарга, ИТХ-ын тэргүүлэгч, төлөөлөгч, нар Дархан-Уул аймагт хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдийн ажлын явцтай танилцах тухай бүрт нь газрын удирдлага, инженерүүд нь барилга угсралтын мэдээг талбай дээр нь танилцуулж мэдээллээр хангаж ажилласан.	Аймаг орон нутгийн удирдлага болон холбогдох байгууллагуудыг барилга угсралтын төсөл хөтөлбөр, арга хэмжээний явцын тухай мэдээллээр хангаж ажиллах.	2-4 р улирал	ИТА ажилчид
2.3 Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.							
2.3.1	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах.	Мэдээлэл, сурталчилгааны зардал 3,0 сая төгрөг	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулах. "Дархан-Хот байгуулалт барилга захиалагчийн газар" цахим хуудсаар дамжуулан олон нийтэд барилгын ажлын явцын талаар мэдээ мэдээлэл тавих.	Байгууллагын "Дархан хот байгуулалт, барилга захиалагчийн газар" цахим хуудсаар дамжуулан Дархан-Уул аймагт 2023 онд техникийн хяналт хэрэгжүүлсэн 210 төслийн ажлын явцын мэдээ, мэдээллийг 273 удаа байгууллагын цахим хуудаст байршуулж олон нийтэд мэдээлсэн. Нийт 147,565 хүнд хүрсэн үзүүлэлттэй байгаа ба 408 хүн таалагдсан товчийг дарж 58 сэтгэгдэл бичжээ. Тус хуудсыг 1402 хүн дагасан үзүүлэлттэй байна. Байгууллагын da.barilga.gov.mn вэб сайтыг 2021 оноос хойш ажиллуулж байгаа ба тус газрын үйл ажиллагаа, тайлан, мэдээг олон нийтэд ил тод мэдээлж байна.	Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах ажлыг зохион байгуулсан байна. Мэдээллийн ил тод байдлыг хангах ажиллах.	1-4 р улирал	ИТА, ажилчид
2.4 Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.							
2.4.1	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах.		Холбогдох хууль, тогтоол, дүрэм, журмыг баримтлан Газрын дарга нь тушаал шийдвэр гаргах ба ажилчид үүрэг даалгаврыг биелүүлж, хэрэгжилтийг хангуулж ажиллах	Барилгын тухай хууль, Авто замын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Усан хангамж, ариутгах татуургын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон холбогдох тогтоол, захирамж, тушаал шийдвэр, одоо мөрдөгдөж байгаа БНБД стандартуудын хэрэгжилтийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллалаа. Хууль тогтоомжийг үндэслэл болгон Даргын А тушаал 119 ш, Б тушаал 69ш гарган үйл ажиллагаандаа мөрдөж тушаалын хэрэгжилтийг хангаж ажилласан. -2023 онд байгууллага, иргэдээс ирүүлсэн нийт 711ш албан бичгийг хүлээн авч бүртгэн хариутай бичгийг 100% хугацаанд нь шийдвэрлэсэн ба ААН, байгууллагууд руу 845ш албан бичгийг хүргүүлж ажилласан байна.	Холбогдох хууль, тогтоол, тушаал шийдвэр, дүрэм журмыг мөрдлөг болгон ажиллах.	1-4 р улирал	ИТА, ажилчид

2.5 Төсөв, санхүү, эдийн засаг, дотоод гадаадын хөрөнгө оруулалтыг төлөвлөх, хэрэгжилтийг зохион байгуулах, зохицуулах.							
2.5.1	Төсвийн төлөвлөгөө боловсруулж батлуулан ажиллагаа явуулах. үйл	Орлого 950.0 сая төг, зардал 922.8 сая төгрөг	2024 оны санхүүгийн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаа явуулах.	2023 оны батлагдсан төсвийн дагуу үйл ажиллагаа явуулсан. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу байр ашиглалттай холбоотой зардал 7.0 сая төгрөг, хангамж бараа материалын зардал 30.4 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 19.7 сая төгрөг, цалингийн зардал 226.9 сая төгрөг, томилолтын зардал 3.7 сая төгрөг, сургалтын зардал 2.4 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 40.6 сая төгрөг, өрх гэрт олгох зардал 1.0 сая төгрөг, зохиогчийн хяналтын зардалд 216.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан. Нийт үйл ажиллагааны зардалд 737.1 сая төгрөг зарцуулж 1 тэрбум 251 сая төгрөгийн борлуулалтын орлого бүрдүүлэн ажилласан байна.	2024 онд 950.0 сая төгрөгийн борлуулалтын орлого олж 922.8 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлнэ. Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулалд 494,7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой зардалд 14,4 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 37,1 сая төгрөг, бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний төлбөрт 88,3 сая төгрөг, бараа ажил үйлчилгээний бусад зардалд 59,3 сая төгрөг, сургалтын зардал 3,0 сая төгрөг тус тус зарцуулна.	1-4 р улирал	Няглан бодогч
2.5.2	Газрын санхүүгийн тайланг олон улсын стандартад нийцүүлэн гаргаж аудитын дүгнэлтээр баталгаажуулж холбогдох байгууллагуудад хүргүүлэх.	1.5 сая төгрөг	Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргаж баталгаажуулах	2023 оны жилийн эцсийн тайланг Пийк ОМ аудит ХХК-иар баталгаажуулан төрийн аудитын газраас зөрчилгүй санал дүгнэлттэй. Холбогдох газруудад санхүүгийн мэдээ тайланг цаг хугацаанд нь гарган хүргүүлсэн.	Санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргаж аудитаар баталгаажуулан холбогдох газруудад хүргүүлэх.	1-р улирал	Няглан бодогч
2.5.3	Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах.		Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулах.	2023 онд борлуулалтын орлого нь 1,251.8 сая төгрөгөөр бүрдүүлсэн ба үйл ажиллагааны зардалд 737.1 сая төгрөгийг зарцуулсан. Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулсан. Аймгийн төсөвт 32.7 сая төгрөгийн ноогдол ашгийг АЗДТГ-т төвлөрүүлнэ.	Татвар, ноогдол ашгийн өглөгийг бууруулж, хяналтын зардлын авлагыг бууруулан ажилласан байна.	1-4 р улирал	Няглан бодогч

2.5.4	Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж хагас, бүтэн жилээр тооллого зохион байгуулах, шаардлагатай үндсэн хөрөнгө, хангамжийн материал худалдан авах, зарцуулах, шаардлага хангахгүй үндсэн хөрөнгийг данснаас хасах.	Тооллогыг хагас болон бүтэн жилээр зохион байгуулах, шаардлагатай үндсэн хөрөнгийг тендер болон шууд худалдан авалтаар гэрээ байгуулан худалдан авах, ашиглалтын шаардлага хангахгүй байгаа үндсэн хөрөнгийг өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрээр акталж данснаас хасах.	Газрын 2023 оны санхүүгийн төсөв, төлөвлөгөөний дагуу бараа материал, шатахууныг анхан шатны баримтыг үндэслэн орлогод авч шаардах хуудсыг үндэслэн ажилтнуудад олгож зарцуулсан. Газрын өмч хамгаалах зөвлөл нь 11 удаа хуралдаж үндсэн хөрөнгө худалдан авах, тооллого зохион байгуулах, сэлбэг хэрэгсэл худалдан авах, үндсэн хөрөнгө акхлах зэрэг шийдвэрүүдийг гаргаж газрын даргад танилцуулж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлсэн. -2023 оны жилийн эцсийн тооллогоор 150,8 сая төгрөгийн үндсэн хөрөнгө тоологдсон. Дараах үндсэн хөрөнгийг шинээр худалдан авсан. 1. Autel EVO 2 PRO 3.0 дрон /10,0 сая төгрөг/ 2. DCP нягт шалгарч барагж /1,5 сая төгрөг/ 3. LX-2 гэрлийн тодрол хэмжигч-770,0 мянган төгрөг 4. Sanwa PDR 302 газардуулгын эсэргүүцэл хэмжигч барагж-1,6 сая төгрөг 5. V380 pro Wi Fi ухаалаг камер 2ш /160,0*2/ 6. Epson eco tank L6490 өнгөт принтер 1,8 сая төгрөг 7. Тойота приус 30 суудлын автомашин-19,8 сая төгрөг. -3,690,190 төгрөгийн үндсэн хөрөнгийн данснаас хасах үйл ажиллагааг зохион байгуулж бүртгэлээс хассан. Автомашины сэлбэг хэрэгсэл авах бүрт байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь хуралдаж фото зургаар баримтжуулан техникийн комиссын акт үйлдсэн.	Хагас бүтэн жилээр тооллого зохион байгуулагдсан байна. Бараа материалын болон үндсэн хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж ажилласан байна. Шаардлагатай үндсэн хөрөнгийг худалдан авах, шаардлага хангахгүй байгаа үндсэн хөрөнгийг ашиглалтаас хассан байна.	1-4 дүгээр улирал	Өмч хамгаалах зөвлөл, нягтлан, нярав
-------	---	---	--	---	-------------------	--------------------------------------

2.6 Хууль тогтоомж, бодлого, төсөл, зэргийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдлийн удирдлагаар хангах.

2.6.1	Хууль тогтоомж, бодлого, төсөл, Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, дотоод аудит хийх, эрсдэлийн удирдлагаар хангах.		ИТА, албан хаагчдын ажлын биелэлтэд хяналт шинжилгээ хийх.	Улсын комиссоор ашиглалтад оруулсан барилга байгууламжуудад гарсан зөрчлийг ашиглагч байгууллагуудаас ирсэн гомдол, саналыг үндэслэж гүйцэтгэгч байгууллагуудаар баталгаат хугацаанд нь засварлуулах ажлыг хяналт гүйцэтгэж байсан инженерүүдээр хариуцуулан гүйцэтгүүлсэн. Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газраас 2022 оны үйл ажиллагаанд гүйцэтгэлийн аудитын шалгалт хийсэн ба аудитаар илэрсэн барилга угсралт, авто зам, гэрэлтүүлгийн 8ш зөрчил дутагдлуудыг арилгуулах албан шаардлага ирүүлсний дагуу гүйцэтгэгч байгууллагууд руу албан бичиг хүргүүлэн засварлуулах үүрэг даалгавар өгсөн. Ажил удааширалтай явагдаж байгаа зарим төсөл арга хэмжээнд дотоод зохион байгуулалт, хүн хүчийг нэмэгдүүлж ажил эрчимжүүлэх үүрэг даалгаврыг тухай бүр албан бичгээр хүргүүлэн ажиллалаа.	Хэрэгжих төслүүдийг чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлж, ажлын биелэлтэд дүгнэлт өгөх.	1-4 улирал	Газрын удирдлага, ерөнхий инженер
2.6.2	Газрын үйл ажиллагааны төлөвлөгөө, тайланг боловсруулан батлуулж холбогдох байгууллагуудад цаг хугацаанд нь хүргүүлэх.		Үйл ажиллагааны тайлан, төлөвлөгөөг хүргүүлэх.	2023 оны эхний хагас, бүтэн жилийн эцсийн гүйцэтгэлийн тайлан аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т, 2023 оны үйл ажиллагааны тайлан буюу объект тус бүрийн тайланг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-т, санхүүгийн тайланг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагын ХШҮ-ний тайланг аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэст хүргүүлсэн. 2023 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т хүргүүлэн батлуулж үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан. Барилга угсралтын ажлын явцын 7 хоног бүрийн мэдээг аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ, БХТ-д хүргүүлсэн. Мөн байгууллагын цахим хуудсаар дамжуулан Дархан-Уул аймагт хэрэгжиж байгаа барилга угсралт, авто зам, ИШС, гэрэлтүүлгийн төслүүдийн ажлын явцыг фото зургаар баримтжуулан олон нийтэд хүргэсэн.	Төлөвлөгөө, тайланг аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, агентлагт хүргүүлэх.	1-4 улирал	Ахлах инженер, бичиг хэрэг

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
ЦАХИЛГААНЫ ИНЖЕНЕР БӨГӨӨД АХЛАХ ИНЖЕНЕР

М.З.Х

У.ЗАЯАХҮҮ

h/